



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№37 /251/

2022.02.23

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 310 ДУГААР АНГИД АЖИЛЛАВ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай тэргүүтэй ЗХЖШ-ын I орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр нарын албаны удирдлагууд өнөөдөр Зэвсэгт хүчний 310 дугаар ангид ажиллав. Тус ангийн захирагч хурандаа Н.Бат-Эрдэнэ ангийн товч танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, онцлог, үүрэг гүйцэтгэлт, цэргийн сургалт бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаа, өнгөрсөн онд хийсэн зарим бүтээлч ажил, тулгамдсан асуудал, цаашид хийхээр төлөвлөж буй ажлын талаар мэдээлэл өглөө. "Цэрэг хаана-Бид тэнд" уриатай

Зэвсэгт хүчний 310 дугаар анги нь Улаанбаатар цэргийн хүрээний анги, салбаруудыг хүнс, хувцас хэрэглэл, эмнэлгийн хангалт, авто хуягт техник, барилга, орон сууцны материал хангалтын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд өдөрт 150-170 хүн хүлээн авах хүчин чадал бүхий "Найман шарга" амралтын газар, 8 га газар бүхий Мод үржүүлгийн сургалтын төв болон Хөдөө аж ахуйн экологийн алба, эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг зэргээрээ онцлогтой анги юм.

Ангийн удирдлага уулзалтын үеэр тус ангид тулгамдаад байгаа хэд хэдэн асуудлыг хөндлөө. Тухайлбал, тус ангийн тавиулан, Цагаандаваа, Хужирбулангийн

объектууд гэр хороолол, айл өрхийн дунд байрладаг нь ангийн аюулгүй байдал, үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдалд сөргөөр нөлөөлдөг, мөн барилга байгууламж, агуулах нь насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссанаас материал хэрэгслийн хадгалалтын чанарыг хангадаггүй талаар дуулгасан бөгөөд Налайх дахь нөөцийн объектод ангийг нүүлгэн шилжүүлэх, ангийн агуулахын дээврийг яаралтай засварлах талаар саналаа танилцуулав. Батлан хамгаалахын дэд сайд харьяаллын олон объектуудаа зөв зохион байгуулах, үйл ажиллагаандаа менежменттэй хандах, байгаа зүйлдээ эзний сэтгэлээр хандах, тулгамдсан асуудлаа шат дараалан шийдэх талаар чиглэл өглөө. Түүнчлэн удирдлагууд "Ахлагч" хотхон болон Налайх дахь нөөцийн объектын үйл ажиллагаатай танилцсан юм.



## "ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИУДЫН БЭЛЭН БАЙДАЛ, ШТАБЫН БЭЛТГЭЛ" СЭДЭВТ ЦУГЛАРАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын харьяа нэгтгэл, ангиудын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нарын цугларалт энэ сарын 22-23 ний өдөр ЗХЖШ-ын Материал, техникийн газрын хурлын танхимд явагдаж байна.

Тусгай хүчний цэргийн командлалын харьяа нэгтгэл, ангиудын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нарын 70 гаруй хувь нь 2021 онд томилогдсон аж. Тиймээс харьяа нэгтгэл, ангиудын штабын дарга нарт ажлын үүрэг, чиглэл өгөх, Тусгай хүчний цэргийн хөгжлийн бодлогыг тайлбарлан таниулах зорилгоор дээрх

цугларалтыг зохион байгууллаа.

"Тусгай хүчний цэргийн командлалын харьяа нэгтгэл, ангиудын бэлэн байдал, штабын бэлтгэл" сэдвээр явагдсан тус цугларалтаар анги, салбарт хөтлөгддөг баримт бичгүүдийг төлөвлөх, байлдааны буудлага, хээрийн гаралтуудыг явуулах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, эрүүл мэндийн хангалтыг зэргийг зохион байгуулахад чиглэсэн штабын дарга нарын анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгосон юм.

Төгсгөлд нь нэгдсэн хэлэлцүүлэг өрнүүлж, бие бүрэлдэхүүнд албан даалгавар, үүрэг чиглэл өглөө.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,868.00	2,870.0
EUR	3,245.0	3,260.0
CNY	452.00	453.00
RUB	36.00	38.00
JPY	24.86	25.00
KRW	2.40	2.41

### ЗУРХАЙ



2022.02.23 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 22/

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ГУРВАН ХӨХ УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.45-18.26

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал: Огторгуй

Аргын тооллын 2 сарын 23. Буд гараг. Билгийн тооллын 22, Онгоц одтой, улаагчин хонь өдөр. Өдрийн наран 7 цаг 45 минутад мандан, 18 цаг 26 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр, хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн.

Салхи санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойшоо мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,271,053 /69.8%/	2,172,432 /66.8%/	1,019,936 31,0%
		97,706 /3,0%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8216 +112	55	8042

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 427,958,361

Эдгэрсэн

Нийт: 355,838,618

Нас барсан

Нийт: 5,924,000



Цахим шууданд

**АХМАДЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА**



Өнөөдөр Батлан хамгаалахын сайдын дэргэдэх ахмадын зөвлөл хуралдлаа. Хуралдаанд Ахмадын зөвлөлийн дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржав, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хурандаа С.Ванчинхүү, БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хурандаа Д.Ганбат, ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн дарга хурандаа Н.Гантөмөр, “Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын захирал бэлтгэл бригадын генерал Д.Ганбаатар, ЗХЖШ-ын Ахмадын хорооны дарга чөлөөнд байгаа хошууч генерал Д.Бадам, ҮБХИС-ийн Ахмадын хорооны дарга бэлтгэл хурандаа Х.Батдэлгэр, ЦТЭ-ийн дарга хурандаа С.Батболд, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Т.Лодойдамба нар оролцлоо. Бэлтгэл хошууч генерал Д.Магсаржав хурлын эхэнд хэлэлцэх асуудлуудын талаар танилцуулав. Мөн ахмад настны талаар салбарын байгууллага, командлал, нэгтгэл, ангийн удирдлагуудад хүргүүлсэн зөвлөмжийн талаар хэлэлцлээ. Анги, байгууллага болон ахмадын зөвлөл хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилгоор хүргүүлсэн тус зөвлөмжид туссан ахмад настны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулсан юм. Тухайлбал, салбарын ахмадуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих, тэдний алдар гавьяаг тэмдэглэх, сурталчлан таниулах, арга туршлагыг нь үйл ажиллагаандаа нэвтрүүлэн залуу үеэ сурган дадлагуулах зэрэг асуудлуудыг тусгажээ.



**Монгол цэрэг энхийн үйлсэд**

**ТАНЫ СОНОРТ**

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулсан бэлэг дурсгалын зүйлсийн багцыг та бүхэнд танилцуулж байна.

Эдгээр багц бэлэг дурсгалын зүйлсийг чанартай, тогтоосон хугацаанд нийлүүлэх сонирхолтой албан байгууллага, хувь хүн үнийн саналаа auttoc@mil.gov.mn

цахим хаягаар илгээх боломжтой.

Мөн бэлэг дурсгалын зүйлсийг захиалах цэргийн алба хаагчид нэгтгэл, анги, байгууллага саналаа төрлийн цэргийн командлал, газар, хэлтсээрээ дамжуулан ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст ирүүлнэ үү.

**УУЛЧИН ДАЙЧИД ЦАСНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу цасны бэлтгэл сургалт, 60 км-ын явган маршийг цогцолбор байдлаар энэ сарын 16-18-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Бугат сумын Улаантолгой багийн Зээгийн даваанд зохион байгууллаа.

Уг сургалтыг уулын тусгай батальоны гүйцэтгэх үүргийн онцлог, сургалт бэлтгэлд нийцүүлж тайван болон дайны үед үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийн зайлшгүй шаардагдах мэдлэг, дадлага, чадварыг олгох, тэдний цэргийн хэргийн болон тусгай үүрэг гүйцэтгэх үр чадварыг нэмэгдүүлэх, сурган дадлагуулах, салаа, тасаг (бүлэг)-ийн бэлэн байдлыг хангах, харилцан ажиллагаа бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх зэрэг олон зорилгын хүрээнд зохион байгуулсан юм.

Цасны бэлтгэл сургалтаар “Уулархаг газар оронд өвлийн нөхцөлд жижиг бүлгийг тусгай ажиллагаанд бэлтгэх” сэдвийн хүрээнд цэргийн алба хаагч нэг бүрийг өндөр уулаас цанаар бууж сургах, олс өндрийн бэлтгэл,



байр зүйн баримжаалал, шөнийн нөхцөлд зүг чигийг тодорхойлох зэрэг хичээлийг дадлагаар зохион байгуулж, өвлийн нөхцөлд өндөр уулын бүсэд үүрэг гүйцэтгэх шаардлагатай цогц мэдлэгийг олгов.

Мөн 60 км-ийн явган маршийг “Хүйтний улиралд, өндөр уулын бүсэд салааны тактикийн бүлгээр тусгай үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх нь” сэдвийн хүрээнд цэргийн алба хаагчдыг уулархаг газар оронд явганаар болон цанаар, мөстөн газар оронд хөдөлгөөн үйлдэх, үүрэг гүйцэтгэх дадлага чадварыг

нэмэгдүүлэн, салаа, тасгийн захирагч нарын үүссэн цагийн байдалд оновчтой шийдвэр гаргах арга барилд сургах зорилготой явуулсан юм. Энэхүү 60 км-ийн маршийн маршрутыг 3 хэсэгт хувааж энхийн хэсэгт 10 км-ийг цанаар, хоёрдугаар хэсэгт 35 км-ийг уулархаг газар орноор, гуравдугаар хэсэгт 15 км-ийг мөстөн газар орон / ховд голын мөс/ дээгүүр муурын хумс ашиглан мотобуудлагын тасгийг олонд оруулж хөдөлгөөн үйлдсэнээр онцлог байлаа.

Энэ удаагийн цасны сургалт нь цэргийн алба хаагчид уулархаг газар районд үүрэг гүйцэтгэх дадлага чадварыг нэмэгдүүлж, салаа, тасгийн захирагч нар үүссэн цагийн байдалд оновчтой шийдвэр гарган удирдах арга барилд суралцан дадлагдаж, өндөр уулын бүсэд тусгай хэрэгсэл ашиглан туулах, хүйтний улиралд амьд гарах ухаанд суралцах, бие бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагаа, бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлсэн гэх мэт олон онцлог туршлага хуримтлуулсан үр дүнтэй сургалт боллоо.

Соёл хүмүүжлийн офицер дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД



**БАЙЛДААНЫ БУУДЛАГАТАЙ ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**



Зэвсэгт хүчний 017 дугаар анги 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт полигоны дадлагыг энэ сарын 14-19-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн районд зохион байгуулан хээрийн гаралтын төгсгөлд “МБР байрын хамгаалалтад” сэдвээр ББТХС-ыг амжилттай зохион байгууллаа.

Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг хоёр шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нэгдүгээр шатанд “Ангийн офицеруудтай БИТХ хөдөлгөөн үйлдэж байрлах” сэдвээр хоёр хоногийн КШС-ыг зохион байгуулж, хоёрдугаар шатанд “МБР-ын байрын хамгаалалтад” сэдвээр байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг явуулсан юм.

Тус сургуулиар офицеруудын байлдааныг бэлтгэж явуулах дадлага чадвар, бие бүрэлдэхүүний бие бялдар, тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл, байлдааны зэвсэглэл, техникүүдтэй харьцах дадлагыг дээшлүүлсэн, ангийн үндсэн болон хуулиар хүлээсэн бусад үүргийг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

Сургуулийн бэлтгэлийн үед Батлан Хамгаалахын сайдын баталсан удирдамжийн дагуу ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга хурандаа Н.Лхагвасүрэнгээр ахлуулсан шалган туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн ББТХС-ийн төлөвлөлтийн баримт бичиг, цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, коронавируст халдвар /КОВИД-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хэрхэн төлөвлөж, зохион байгуулж буйд шалган туслах ажлыг явуулж, байлдааны буудлагыг төлөвлөлтийн дагуу осол зөрчил, аюулгүй ажиллагааг дээд зэргээр сахиж явуулах талаар холбогдох бүрэлдэхүүнд үүрэг, даалгавар, заавар зөвлөмж өгч ажиллав.

Хошууч М.ДАВААНЯМ



**ШАТАЖ БАЙСАН АВТОБУСНЫ ГАЛЫГ УНТРААСАН ХҮҮГ “НИЙСЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ СУРАГЧ”-ААР ШАГНАЛАА**

Нийслэлийн тэргүүний ерөнхий боловсролын “Тэмүүжин өрлөг” сургуулийн 9<sup>а</sup> ангийн сурагч Д.Хүчитбаатар шатаж байсан автобуснаас зорчигчдыг гаргаж, асаж буй галыг унтраахад оролцжээ. Тиймээс түүнийг Нийслэлийн тэргүүний сурагчаар шагнаж, урамшуулсан юм.

Тэр бээр “Нийслэлийн тэргүүний сурагч болно гэж төсөөлж байгаагүй. Тэргүүний сурагчаар шагнуулах гавьяа байгуулсан өөрөөрөө бахархаж байна. Намайг дэмжиж тусалсан хүн бүрд баярлалаа. Миний ойр дотнын хүмүүс надаар бахархаж, амжилт хүсэж байгаа” гэв.

Үйл явдлыг тодруулбал тэр бээр хоёрдугаар сарын 15-



ны өдөр Гачуурт чиглэлд явж байсан эмэгтэй жолоочтой автобус шатах аюул нүүрлэхэд дотор байсан хүмүүсийг гаргаж, асаж буй галыг унтраасан юм.

**“ТАКТИК, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЦОГЦОЛБОР 30-КМ”-ИЙН ЯВГАН МАРШ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**





**Зэвсэгт хүчний 232 дугаар анги**

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг нэмэгдүүлэх, алба салбаруудын

харилцан ажиллагааг хангах зорилгоор бие бүрэлдэхүүнийг 3 бүлэгт хуваан “Тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор” 30-км-ийн явган маршийг ангийн байнгын байрлал, “Духан”, “Цэргийн овоо”, “Нэргүй өндөрлөг” “Тосон нуур” гэсэн маршрутаар хийчээлийн 4 цэгээр зохион байгууллаа.

Ахмад Ц.ОТГОНСҮРЭН



\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018  
Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)